

Мэдээллийн технологи, программ хангамж хариуцсан ахлах мэргэжилтэн, Гантөмөр Санчир

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг бий болгож, санхүү, хөрөнгө оруулалт, хууль, эрх зүй болон гадаад харилцаа, хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах асуудлыг хариуцах, яамны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангана.							
1	Мэдээллийн системүүдийг үйл ажиллагаанд хяналт тавьж, системийн нууцлал, аюулгүй байдал болон байнгын найдвартай ажиллагааг хангана.	Системүүд хэвийн ажилласан байх, хувиар	Тухай бүр ажилласан.	Мэдээллийн системүүдийг үйл ажиллагаанд хяналт тавьж, системийн нууцлал, аюулгүй байдал болон байнгын найдвартай ажиллагааг хангаж ажилласан байна.	Эдийн засаг, хөгжлийн яамны өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагддаг системүүдийн тасралтгүй хэвийн ажиллагааг ханган, хяналт тавьж ажилласан. Үүний хүрээнд: Яамны албан бичгийн систем /Office 365/ power automate, power apps хөгжүүлэлтүүдийг "Mogul" ХХК-ийн инженерүүд, Сангийн яамны мэдээлэл технологийн мэргэжилтнүүдтэй хамтран сайжруулалт, хөгжүүлэлт хийсэн. 1.Office365 - Шинээр ажилд томилогдсон албан хаагч болон гэрээт зөвлөх нийт 39 хэрэглэгчийн эрх нээж өгөн, систем дээр тохируулгын ажлыг хийж гүйцэтгэсэн. 2.ADDC - med.gov.mn домэйн удирдлага дээр шинээр ажилд томилогдсон 39 хэрэглэгчийг нэмж, ажлаас чөлөөлөгдсөн идэвхгүй байгаа хэрэглэгчдийг ангилж, идэвхгүй хэрэглэгчид цэсрүү оруулсан. Мөн Засгийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

246

					газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор батлагдсан бүтцийн өөрчлөлтийг систем дээр хийсэн. 3.Erp.e-mongolia.mn /Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем/ - Шинээр ажилд орсон төрийн албан хаагч болон чөлөөлөгдсөн, түр чөлөөлөгдсөн албан хаагчдын мэдээллийг тогтмол шинэчилсэн. - Цаг бүртгэлийн цэсэд яамны нийт албан хаагчдыг ажлын цагийг уян хатан болгох талаар гарсан шийдвэрийн дагуу 4 төрлийн цагийн хуваарийн зохицуулалтыг систем дээр тохируулсан, - Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/106 дугаар "Зайнаас ажиллуулах тухай" тушаалаар батлагдсан "Албан хаагчийг зайнаас ажиллуулах журам" болон " Зайнаас ажиллах боломжтой албан тушаалын жагсаалт, хуваарь"-ын дагуу тухайн албан хаагчийн хүсэлтийг газар, нэгжийн дарга нарлуу тухайн албан хаагч илгээн явуулах, тухайн хүсэлтийг шийдвэрлэх боломжийг тус тус газар, нэгжийн дарга нарт эрхийг нь цаг бүртгэлийн систем дээр тохируулга хийн ажилласан билээ. - Erp.e-mongolia.mn /Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем/ дээр батлагдсан бүтцийн хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яамны нийт албан хаагчдын албан тушаал болон газар, хэлтсийн нэршлийг шинэчилж, засварласан.		
2	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн	Хэрэгжилтийн явц, хувиар	ТЖАХ-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө,	ТЖАХ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг /https://plan.igovernment.mn/planemployee/ систем дээр цаг тухай бүрт нь гаргаж,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар,	100%

	төлөвлөгөө, тайланг хагас, бүтэн жилээр гаргаж дүгнүүлнэ.		тайланг дүгнүүлсэн.	батлуулж, тайланг гаргаж, холбогдох газарт хүргүүлсэн байна.	удирдлагаар батлуулан дүгнүүлэн ажилласан.	5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
3	Яамны цахим хуудсаар дамжуулан иргэн, аж ахуй нэгжүүдэд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангана.	Мэдээ мэдээлэл тухай бүрд орсон байх, хувиар	Яамны цаг үеийн шинэ мэдээ, мэдээллээр байнга баяжуулж, хэвийн ажиллагаанд нь хяналт тавьж ажилласан.	Цахим хуудсыг яамны цаг үеийн шинэ мэдээ, мэдээллээр байнга баяжуулж, хэвийн ажиллагаанд нь хяналт тавьж ажилласан байна	1. Яамны үндсэн цахим хуудас /www.med.gov.mn/, сошиал хуудас /https://www.facebook.com/medgovMN/ тогтмол хөтөлж, иргэд болон аж ахуй нэгжид тогтмол мэдээ, мэдээлэл хүргэх зорилгоор 128 төрлийн мэдээ, мэдээлэл, нийт хандалтын тоо 42130. 2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс shilen.gov.mn 2.0 системд 5 төрлийн шалгуур үзүүлэлтийн дагуу нээлттэй мэдээллийг цахим хуудсандаа байршуулан 1, 2 болон 4 улиралд илгээн, үнэлүүлсэн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
4	Яамны дотоод сүлжээ, сервер, компьютер тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж, мэдээллийн аюулгүй байдлыг хангана.	Мэдээллийн системүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, системийн нууцлал, аюулгүй байдал болон байнгын найдвартай ажиллагааг хангаж ажиллана.	Системүүд хэвийн ажилласан байх, хувиар	Мэдээллийн системүүдийг үйл ажиллагаанд хяналт тавьж, системийн нууцлал, аюулгүй байдал болон байнгын найдвартай ажиллагааг хангаж ажилласан байна	Яамны гадаад, дотоод сүлжээний найдвартай, тасралтгүй хэвийн хангаж ажиллах; яамны дотоод сервер хэвийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах, үйлчилгээг хийх; ажилтнуудын техник хэрэгслийн ашиглалтын нормд хяналт тавьж, компьютер, техник хэрэгслийн ашиглалтад мэргэжлийн зөвлөгөө өгөх; Мэдээллийн технологи, техник хэрэгслийн сайжруулалт, шинэчлэлийг тухайн жилийн төсвийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах, худалдан авах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас - Хяналтын камерыг 1, 5, 6, 7, 8, 9, 12 давхарт нийт 35	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

100%

					ширхэгийг суурилуулж харуулын байранд хяналтын 2 дэлгэц дээр холболт хийн, хяналт тавин ажиллахаар тохируулсан. - Сүлжээний төхөөрөмжүүдийн тохиргоог хийж давхарт бүрт утасгүй сүлжээний орчинг дахин шинэчилж, утасгүй сүлжээний 3 төхөөрөмж шинээр суурилуулсан. Хэрэглэгчийн хаяг дүүрсэн байсныг засаж, нууц үгийг update хийн, шинэчлэлтийг тогтмол хийж гүйцэтгэсэн. - Албан хаагчдын хэрэгцээнд зориулан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 37ш иж бүрэн компьютер төрийн худалдан авах ажиллагааны систем tender.gov.mn-ий цахим дэлгүүрээс худалдан авалт хийж, компьютер тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг ханган ажилласан. - Хяналт, нэвтрэлтийн төхөөрөмжийг мөн адил төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу худалдан авалтийг хийж, 1 давхарт хяналтын рентген төхөөрөмж, явган хаалт нэвтрэх төхөөрөмжийг суурилуулсан, 10 давхарт серверийн өрөөнд зориулалтын шал болон мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс нэвтрэхэд кодоор онгойх хаалганы цоож суурилуулсан, 9 болон 8 давхрын хурлын танхимд нэвтрэх цоож, картаар нэвтрэх цоож суурилуулж, хяналт тавин ажилласан.		
5	Яамны домэйн нэрийг удирдах, дэд домэйн үүсгэх, устгах, хэвийн ажиллаж байгаад нь хяналт тавьж,	Тухай бүр хангаж ажилласан байх, хувиар	-	Яамны гадаад, дотоод сүлжээ, мэдээллийн системийн аюулгүй байдал хамгаалагдсан байна.	- Яамны med.gov.mn домэйн нэрийг удирдах, дэд домэйн үүсгэх, устгах, хэвийн ажиллаж байгаад нь хяналт тавьж ажиллаа. Мэдээллийн системүүд болон цахим хуудсууд ашиглалт, хэвийн үйл ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлын талаар Үндэсний Дата Төв болон Мэдээллийн аюулгүй байдлын газартай	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар,	100%

	Үндэсний Дата Төв болон Мэдээллийн аюулгүй байдлын газартай хамтран ажиллах				хамтран ажиллав. - Яамны ...@med.gov.mn нэр дээрх цахим шууданг макрософт оффис 365 -ын мэйл сервер дээр зохион байгуулж, цахим шуудангийн хэрэглэгчдийн зохицуулалт болон түүний хэвийн, тасралтгүй ажиллагааг хянаж ажиллаж, бүртгэх, хасах болон хэрхэн ашиглах заавар, зөвлөмжийг ажилтнуудад өгч хэвийн ажиллагааг хангаж, хяналт тавин ажиллаа. ADDC контрол дээр албан хаагчдын мэдээллийг шинэчлэн оруулсан. Төслийн хүрээнд Үндэсний дата төв дээр сервер байршуулах ажил хийгдэхээр төлөвлөгдсөн. - med.gov.mn домэйн дээр SSL https:// тохируулга хийсэн.	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
6	Удирдлагаас өгсөн цаг үеийн шинжтэй үүрэг даалгавар, нэмэлт ажлуудыг хуулийн хугацаанд гүйцэтгэх	Хэрэгжилтийн явц /хуваарь/	-	Үүрэг даалгавар, нэмэлт ажлуудыг хугацаанд нь гүйцэтгэсэн байна.	Удирдлагаас өгсөн цаг үеийн шинжтэй үүрэг даалгавар болон нэмэлт ажлуудыг хуулийн хугацаанд тухай бүрд хийж гүйцэтгэсэн. - Шинэ ажилтны гарын авлага шинэчлэх ажлыг дотоод бичгээр газруудаас санал авсан. Саналуудыг нэгтгэн хянуулахаар болсон. - Биеийн тамир, спорт зөвлөлийг Ц.Дашдондогтой хамтран шинээр байгуулах тушаалын төслийг боловсруулж, хянуулан, ТНБД-ын тушаалаар байгуулсан. 2024 оны 04-р сарын 25-27 өдрүүдэд Эдийн засаг, хөгжлийн яамны Шилжин явах 5 төрөлт спортын аварга шалгаруулах тэмцээнийг нийт 7 багийн дунд амжилттай зохион байгуулсан. Энэхүү тэмцээний дараагаар яамны шигшээ багийг бүрдүүлэн жил бүр уламжлан зохион байгуулагддаг "Засгийн газрын цом 2024"-т баг тамирчдын хамт амжилттай оролцон шатрын төрөлд эмэгтэй баг алтан медаль, 5 төрөлт спортын нийлбэр дүнгээр 18 яамнаас 10-р байранд орсон амжилттайгаар энэхүү	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					тэмцээнд оролцсон билээ. - "Хаврын бүх нийтээр мод тарих аян"-нд ТЗУГ албан хаагчид амжилттай оролцон, мод тарих үйл ажиллагааг зохион байгуулсан. - "Эрүүл агаар эм" явган алхалтыг нийт 6км зайтаагаар Горхи-Тэрэлжийн цогцолбор Арьяабалын хийд дээр албан хаагчдынхаа дунд амжилттай зохион байгуулсан. - Ер системийн талаарх танилцуулга ppt бэлтгэн танилцуулсан. - Монгол бичгийн сургалтын хуваарийг гаргаж, нийт албан хаагчдыг сургалтанд идэвхтэй хамрагдах ажлыг хийж гүйцэтгэсэн. - Цаг бүртгэлийн төхөөрөмж дээр удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу картаар цаг бүртгэл унших горимыг идэвхгүй болгосон. - Яамны албан хаагчдаас санал хүсэлт авч газар, хэлтсүүдэд утасгүй телефон утас авах үнийн санал авч танилцуулан, худалдан авалтыг хийж, утаснуудыг газруудад тараан өгсөн. - Төрийн албаны тусгай шалгалтыг 3 удаа амжилттай зохион байгуулсан.		
--	--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7

4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Мэдээллийн технологийн чиглэлээр зохион байгуулагдах сургалтад хамрагдаж мэдлэг мэдээллээ дээшлүүлэх	Сургалтад хамрагдсан байх	Сургалтад хамрагдсан байна.	Сургалтад хамрагдсан байна.	- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.12 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт ЦХХХЯ-наас гаргуулах үйл ажиллагааг хялбарчлах зорилгоор "Мэдээллийн системийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем" (e-governance.gov.mn)-ийг хөгжүүлэн, ашиглалтад оруулсан. Тус системийг танилцуулах сургалтанд хамрагдсан. - "Хиймэл оюун ухааны хэрэглэ, цаашдын чиг хандлага: АНУ-ын жишээн дээр" сургалтад хамрагдсан. - "Shilen.gov.mn" системийн танилцуулга онлайн сургалтад хамрагдсан. - Гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим сангийн сургалтанд хамрагдсан. - E-mongolia academy-аас зохион байгуулсан Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас /www.gov.mn/ системийн талаарх админы сургалтанд 2024 оны 10-р сарын 17-ны өдөр хамрагдсан. - PAESLLER-н танилцуулга, мониторинг бүтээгдэхүүний техникийн Live демотой танилцах вебинарт 2024	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

0001

					оны 12-р сарын 05-ны өдөр хамрагдсан.		
2	Хариуцсан ажил үүргийн дагуу холбогдох сургалт семинарт оролцох	Хариуцсан ажил үүргийн дагуу холбогдох сургалт семинарт оролцсон.	-	Хариуцсан ажил үүргийн дагуу холбогдох сургалт семинарт оролцсон байна.	- Удирдлагын академиас зохион байгуулдаг Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтанд 2024 оны 09-р сарын 20-ны өдрөөс 12-р сарын 13-ны өдрийн хооронд суралцаж байгаа. Сургалт дууссаны дараа тухайн хичээлүүд дээр төгсөлтийн шалгалт өгч сертификат авна. - Төрийн албаны зөвлөлөөс "Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд" сэдэвт сургалт, Төрийн албан хаагчийн ёс зүй/ гомдол, мэдээлэл, зөрчлийг шийдвэрлэх" сургалтуудад цахимаар оролцсон.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Мэдээллийн технологи, программ хангамж хариуцсан ахлах мэргэжилтэн, Гантөмөр Санчир /........../

Огноо:2024.12.25.....